



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251
Утас: (976-51) 26 71 68, Факс: (976-11) 31 23 15,
Цахим шуудан: info@mrtd.gov.mn,
Цахим хуудас: www.mrtd.gov.mn

2023-05-16 № 08а/2309

танай _____ -ны № _____ -т

Г Санал, зөвлөмж хүргүүлэх тухай

Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтарт 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдөр танилцуулсан тус төвийн захирлын 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/20 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс боловсруулж буй “Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч төмөр замын байгууллагын нэгдсэн технологийн горим”-ын төсөлд дараах санал, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Төмөр замын тээврийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.3.6-т заасныг, мөн Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-т заасныг тус тус үндэслэн “Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч төмөр замын байгууллагын нэгдсэн технологийн горим”-ыг боловсруулж, батлахдаа Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 61 дүгээр зүйлийн 61.1, 61.2, 61.3, 61.4, 62 дугаар зүйл, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.4, 66 дугаар зүйлийн 66.1.1-т заасныг тус тус баримтлан боловсруулах,

2. Төмөр замын тээврийн хуулийн өргөн барьсан шинэчилсэн найруулгын төсөл батлагдаагүй байх тул технологийн горимыг одоо хүчин төгөлдөр мөрдөж буй хуулийн нэр томьёо, дүрэм журмын агуулгад нийцүүлэн боловсруулах,

3. Суурь бүтцүүдийн хооронд галт тэрэг солилцох технологийн горимуудыг тус баримт бичигт тусгах зэрэг болно.

ТӨМӨР ЗАМ, ДАЛАИН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Х.ИТГЭЛТ

080003098